

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН 10 ДУГААР САРЫН
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2022.10.19

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
Ерөнхийлөгчийн зарлиг							
1	1	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, үүсгэн байгууллагын шалтгаан, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэрэг үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Аймгийн хэмжээнд Дэлгэрхангай, Луус сумын Эрүүл мэндийн төв, Цагдаагийн газар Уламжлалт ангахаах ухааны төв зэрэг 4 байгууллага гадна хаягаа үнэсний бичгэн гэрлэн хаяг шинээр хийсэн нь үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа болж байна.	100		

3	2		4.. Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн ажилтан, албан хаагч нарт Цэгцбилиг сургуулийн багш Ц.Цэвэлмаа монгол бичгийн модуль сургалтыг зохион байгуулж байна. Мөн аймгийн хэмжээнд 6-12-р ангийн нийт 4311 хүүхдэд монгол хэлний 60 багш мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ЭЕШ-д бэлтгэх давтлага хичээллүүлж байна. Чанарын үнэлгээний шалгалтыг Говийн-Ирээдүй, Эрдэнэдалай, Эрдмийндалай, Политехнологийн коллежийн сурагчдаас үндэсний бичгийн хэрэглээг тодорхойлох зорилгоор БҮТ-өөс чанарын үнэлгээний шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтад нийт 4 сургуулийн 6,10,12-р ангийн 500 хүүхэд хамруулсан. Энэ үйл ажиллагаа нь сурагчдад монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх олон талт арга хэмжээ болж байна.	70		
	5	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-08-27 Дугаар 2021_23	1.1. Монгол Улсын сум, нийслэлийн хороо бүрийн төлөөллийг жигд хангаж, тухайн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтад харьяалах сум, хороондоо хамгийн өндөр оноо авсан тус бүр 1 иргэнийг дотоодын төрийн өмчийн их сургуулийн дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцуулахад бэлтгэх, тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрт элсүүлэх.	ЕБС-ийн 2021-2022 оны хичээлийн жилд элсэлтийн ерөнхий шалгалтад харьяалах сум, хороондоо хамгийн өндөр оноо авсан аймгийн 5 суралцагчийг БШУЯ-наас ирүүлсэн нэрсийн дагуу дотоодын төрийн өмчийн их сургуулийн дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцуулахад бэлтгэх, тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрт хамруулсан нь тэднийг урамшуулсан, дэмжсэн арга хэмжээ болов.	100		
Үнэлгээний дундаж						90%	

ТАЙЛАН ХЯНАСАН:

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН АЛБАНЫ ДАРГА

Л.ОЮУНБАЯР

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН

Ц.ОТГОНЖАРГАЛ